



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СБА-2024/06/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Баруун-Урт сум 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Даваа Утас: 70518396 Аудитын менежер: М.Нарантуяа Утас: Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn Аудитор: Ө.Золзаяа Утас: 70512127 Цахим хаяг: zolzayau@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	8
3.1 Албан шаардлага	8
3.2 Зөвлөмж	9
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	10

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

СҮХБААТАР АЙМГИЙН
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ
ДЭМЖИХ САНГИЙН ДАРГА
Д.ГЭРЭЛБАДРАХ ТАНАА

2024.02.23 № 67
танай _____ - ны№ _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй. Тайлант онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 7 хөтөлбөрт 1,505.3 сая төгрөгийг баталж, гүйцэтгэлээр 1,434.5 сая төгрөгийг зарцуулснаас ажлын байрны санхүүгийн дэмжлэг 47 иргэнд 400,000.0 мянга, хөгжлийн бэрхшээлтэй иргэний санхүүгийн дэмжлэг 34 иргэнд 80,000.0 мянга, малжуулах хөтөлбөрт 70 иргэнд 350,000.0 мянга, ахмад санхүүгийн дэмжлэг 29 иргэнд 125,000.0 мянга нийт 180 иргэнд 955,000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон байна.

Аудитын гол асуудал

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 20 иргэний гэрээний хугацаа дууссан боловч 41,023.5 мянган төгрөгийн эргэн төлөлтийг цаг хугацаанд нь төлөөгүй хугацаа хэтэрсэн үлдэгдэлтэй байгаа бөгөөд гэрээний

үүргээ биелүүлээгүй тус 20 иргэнийг шүүх хяналтын байгууллагад шилжүүлж, авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Бусад асуудлын

Тус сургуулийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 18 арга хэмжээг төлөвлөж, 17 арга хэмжээ хэрэгжсэн ба залуусын оролцоо төсөл улсын хэмжээнд хэрэгжээгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,467,078,162.00</u>	<u>1,877,882,035.00</u>
33	АВЛАГА	1,467,078,162.00	1,877,882,035.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	12,149,000.00	91,137,345.00
335	Бусад авлага	1,454,929,162.00	1,786,744,690.00
3351	Байгууллагаас авах авлага	9,240,000.00	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,445,689,162.00	1,786,744,690.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,467,078,162.00</u>	<u>1,877,882,035.00</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,467,078,162.00</u>	<u>1,877,882,035.00</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,467,078,162.00	1,877,882,035.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,467,078,162.00	1,877,882,035.00
51210	Өмнөх үеийн үр дүн	1,467,078,162.00	1,445,689,162.00
51220	Тайлант үеийн үр дүн	-	432,192,873.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,467,078,162.00</u>	<u>1,877,882,035.00</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,411,878,000.00	1,554,665,622.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	37,800,000.00	1,411,968,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	37,800,000.00	1,411,968,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	37,800,000.00	1,411,968,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		992,228,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	37,800,000.00	103,663,000.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих		316,077,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,374,078,000.00	142,697,622.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	137,930,000.00
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх		137,930,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,374,078,000.00	4,767,622.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,374,078,000.00	4,767,622.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	877,705,200.00	1,122,472,749.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	877,705,200.00	1,122,472,749.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,073,000.00	55,570,024.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,073,000.00	55,570,024.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,073,000.00	55,570,024.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	873,632,200.00	1,066,902,725.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	429,347,961.60	423,958,003.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	429,347,961.60	423,958,003.00

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	112,657,038.40	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	112,657,038.40	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	28,560,000.00	49,340,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,560,000.00	49,340,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	303,067,200.00	593,604,722.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	303,067,200.00	593,604,722.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>534,172,800.00</u>	<u>432,192,873.00</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>534,172,800.00</u>	<u>432,192,873.00</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,424,364,700.00</u>	<u>1,563,905,622.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	50,286,700.00	1,421,208,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	50,286,700.00	1,421,208,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	50,286,700.00	1,421,208,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		992,228,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	37,800,000.00	103,663,000.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	12,486,700.00	325,317,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,374,078,000.00	142,697,622.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	137,930,000.00
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх		137,930,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,374,078,000.00	4,767,622.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,374,078,000.00	4,767,622.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,727,094,200.00</u>	<u>2,177,850,094.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,727,094,200.00	2,177,850,094.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,073,000.00	55,570,024.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,073,000.00	55,570,024.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,073,000.00	55,570,024.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,723,021,200.00	2,122,280,070.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,257,347,961.60	1,378,958,003.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,257,347,961.60	1,378,958,003.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	112,657,038.40	100,377,345.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	112,657,038.40	100,377,345.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	49,949,000.00	49,340,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	49,949,000.00	49,340,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	303,067,200.00	593,604,722.00

213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	303,067,200.00	593,604,722.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>(302,729,500.00)</u>	<u>(613,944,472.00)</u>
14	Бусад эх үүсвэр	328,877,650.00	613,944,472.00
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	328,877,650.00	613,944,472.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>328,877,650.00</u>	<u>613,944,472.00</u>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,467,078,162.00	0.00	1,467,078,162.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,467,078,162.00	0.00	1,467,078,162.00
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,467,078,162.00	0.00	1,467,078,162.00
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,467,078,162.00	0.00	1,467,078,162.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-21,389,000.00	0.00	-21,389,000.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,445,689,162.00	0.00	1,445,689,162.00
D08	Тайлант үеийн үр дүн	432,192,873.00	0.00	432,192,873.00
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,877,882,035.00	0.00	1,877,882,035.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хөтөлбөр, төслийн ангилал, үзүүлэлт		Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Код	Үзүүлэлт	Хөрөнгө	Хөрөнгө
11	НЭГ. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГИЙН ОРЛОГО	1,525,558,000.00	2,173,082,472.00
113	ХБИ ажиллуулаагүйн төлбөрийн орлого	25,000,000.00	49,340,000.00
116	Өмнөх оны үлдэгдэл	-	9,240,000.00
117	ХЭД сангаас хуваарилсан санхүүжилт	1,500,558,000.00	1,500,558,000.00
119	Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт	-	613,944,472.00
2	ЗАРЦУУЛАЛТЫН ДҮН	1,505,325,622.00	2,173,082,472.00
21	2.1 Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ	9,235,000.00	9,235,000.00
211	Ганцаарчилсан ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ	1,095,000.00	1,095,000.00
212	Бүлгээр ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ	8,140,000.00	8,140,000.00
22	2.2 Ажилд зуучлах үйлчилгээ	16,616,000.00	4,759,853.00
221	Ажилд зуучлах үйлчилгээ	4,760,000.00	4,759,853.00
222	Хөдөлмөр эрхлэх чадавхийн үнэлгээ /профайлинг/	10,060,500.00	-
224	Хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөө боловсруулах	1,795,500.00	-
3	ГУРАВ. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ	1,421,007,000.00	1,364,963,150.00
31	3.1 Хөдөлмөрт бэлтгэх сургалт	31,110,000.00	31,050,000.00
32	3.2 Аж ахуй эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг	974,300,000.00	934,179,500.00

33	3.3 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	192,317,000.00	176,836,950.00
34	3.4 Түр ажлын байрыг дэмжих арга хэмжээ	223,280,000.00	222,896,700.00
4	ДӨРӨВ. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	58,467,622.00	55,570,024.00
401	Жижиг зээлийн хүүгийн хөнгөлөлт	700,000.00	-
402	Хөдөлмөрийн тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ болон ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн хэрэгжилтийг хангах	5,000,000.00	4,998,480.00
403	Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, мэдээллийн системийг сайжруулах, шинэчлэх	5,000,000.00	4,993,334.00
404	Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, ажилтнуудын чадавхи бэхжүүлэх сургалт, зөвлөгөөн зохион байгуулах	10,000,000.00	9,996,028.00
405	Хөдөлмөр эрхлэлтийг сурталчлах, олон нийтийг соён гэгээрүүлэх арга хэмжээ, хөдөлмөрийн яармаг, өдөрлөг зохион байгуулах, хууль тогтоомж, эрх зүйн актын уулзалт, хэлэлцүүлэг, зөвлөлгөөн	8,500,000.00	8,500,000.00
406	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд дүн шинжилгээ, хяналт, үнэлгээ хийлгэх	10,000,000.00	9,996,110.00
408	Гарын авлага, маягт, хэвлэмэл материалын эх бэлтгэх, хэвлүүлэх	6,000,000.00	6,000,000.00
411	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих	4,500,000.00	3,942,700.00
414	Хөдөлмөрийн хүрээний суурь зарчим, үндсэн хэрэгжилтийг хангах	4,000,000.00	2,375,750.00
61	ЗУРГАА. ТӨВЛӨРҮҮЛЭЛТ	-	743,322,067.00
6110	Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт - ХЭДСан	-	593,604,722.00
6112	Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт - Сангийн яам	-	20,339,750.00
6120	ХБИ ажиллаагүй төлбөрийн орлого - ХЭДСан	-	58,580,000.00
6132	Санхүүжилтын буцаалт - Сангийн яам	-	70,797,595.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 88,527.0 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 10.7 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 4.3 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 48.4 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 17.9 сая төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

3.1 Албан шаардлага

1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас авсан 20 иргэний гэрээний хугацаа дуусаж, эргэн төлөгдөөгүй байгаа 41,023.5 мянган төгрөгийн зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 (батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах), 41 дүгээр зүйлийн 41.2.3 (төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах), Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3 (хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанаас өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно) дахь заалтуудыг тус тус зөрчсөн

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

ба иж бүрэн байх, хэмжилт ба үнэлгээ, үнэн зөв байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

2. Баруун-Урт, Сүхбаатар, Мөнххаан сумдын нийт 180 иргэнийг хамруулах суурь ур чадварын сургалтыг “Дарь овооны эзэд” ТТБ 5,400.0 мянган төгрөгөөр гүйцэтгэсэн байна. Сургалтыг анхан шатны баримтаар тулган баталгаажуулахад сургалтын хөтөлбөр, суурь сургалт зохион байгуулах гэрээ, сургалтын ирцийн бүртгэл, сургалт зохион байгуулсан тайлангаар хэд хоногийн сургалт явуулсан хугацаа тодорхойгүй /зөрүүтэй/, сургалтын гэрээг дүгнэж акт үйлдээгүй, сургалтын ирцийн бүртгэл дутуу, сургалт явуулсан талаарх зураг, дүрсжүүлсэн бичлэг гэх мэт иж бүрэн нотлох баримтаар дэмжигдээгүй байна. Мөн сургалтын байгууллагын сонгон шалгаруулалтыг нээлттэй зарлаж байгууллагын хэмжээнд зохион байгуулан, Хөдөлмөрийн хэлтэс, аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл болон иргэний төлөөллийг оролцуулсан ажлын хэсгээр тусгайлан боловсруулсан шалгуурын дагуу үнэлүүлж, сургалтын тоон үзүүлэлтээс гадна чанар үр өгөөжийг нэмэгдүүлж, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх шаардлагатай байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 (“анхан шатны баримт” гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог), 13 дугаар зүйлийн 13.7 (Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно), Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4 (хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох), 41 дүгээр зүйлийн 41.2.3 (төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах)-т заасантай нийцээгүй бөгөөд иж бүрэн байх, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын зарцуулалттай холбоотой асуудал:

Илрүүлэлт:

Тээвэр шатахуун зарцуулалтыг анхан шатны баримттай тулгахад жолоочийн тооцооны хуудсанд “Баруун-Урт сум дотор, хяналт үнэлгээний ажлаар, аж ахуйн нэгжүүдээр” агуулгаар хаана явсан нь тодорхойгүй 1,080.0 мянган төгрөгийг зарцуулжээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 (“анхан шатны баримт” гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог), 13 дугаар зүйлийн 13.7 (Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно), Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 (Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм) дахь заалтад нийцээгүй ба иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шатахууны зарцуулалтын анхан шатны баримтыг зааврын дагуу тодорхой бөглөх, хаанаас хаана хүрэх маршрут, чиглэл, схем зураглалаар гаргах, тухай бүрт явсан ажлын тайлан, үр дүнг тайлагнаж, шаардах хуудсаар шатахууны картыг цэнэглэж, зарцуулалтын тайланг гаргаж хэвших

2. Нийцлийн аудиттай холбоотой асуудал:

Илрүүлэлт:

Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.2-т заасны дагуу 2023 онд 25-аас дээш ажилтны нийгмийн даатгалын шимтгэл төлж буй аж ахуйн нэгж байгууллагын судалгааг авч, зарим аж ахуйн нэгжийн хэрэгжилтэд хяналт хийхэд ХЭДС-д холбогдох төлбөрийг бүрэн төвлөрүүлээгүй байх эрсдэлтэй байна. Энэ нь Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй байх, төсвийн орлогыг дутуу бүрдүүлэх, цаг хугацаандаа төвлөрдөггүй жишиг тогтож буй үр дагавартай. Мөн Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.3 (Аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 144.2-т зааснаар хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд ногдох төлбөрийн хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү байх бөгөөд уг төлбөрийг сар бүр Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд төлнө) дахь заалт, Засгийн газрын 2022 оны 253 дугаар тогтоолоор баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүй орон тоо тутамд ногдох төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх журам”-ын 3.7 (ААНБ болон аймаг, дүүргийн хөдөлмөрийн хариуцсан байгууллага санхүүгийн жилийн эцэст тухайн ААНБ-ын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төлсөн төлбөр болон төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөлтийн дүнг эцэслэн нийлж, тооцоог дуусгавар болгоно), 3.8 (журмын 2.1-д заасан аж ахуйн нэгж, байгууллагын нийт ажилтны тоо, үүнээс хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулбал зохих болон ажиллуулж байгаа орон тоо, төлбөрийн хэмжээ, хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэмжээ зэрэг холбогдох мэдээллийг хөдөлмөр, татвар, нийгмийн даатгал, бүртгэлийн асуудал хариуцсан байгууллагууд харилцан солилцож, мэдээллийн систем үүсгэж ажиллана. Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага мэдээллийн системийг удирдлагаар ханган ажиллана) гэсэн заалтуудтай нийцэхгүй байгаа бөгөөд, иж бүрэн байх, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.2 (Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа дөрвөн хувиас доошгүй орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулна) заалтын дагуу хөдөлмөрийн улсын байцаагчаар хяналтыг хэрэгжүүлж холбогдох арга хэмжээг авах, төр захиргааны байгууллагуудтай хамтарч ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 09 дүгээр сарын 30 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Гэрээ дууссан иргэдийн төлөлтийг барагдуулах арга хэмжээ аваагүй	1	41,023.5			1	41,023.5						
Суурь чадварын сургалтын анхан шатны баримтууд хангалтгүй байна	1	5,400.0			1	5,400.0						

Шатахууны зарцуулалт тодорхойгүй, баримтын бүрдэл дутуу	1	1,080.0					1	1,080.0				
ХБИ-ажиллуулагүй төлбөрийг дутуу төвлөрүүлсэн	1	-					1	-				
Дүн	4	47,503.5			2	46,423.5	2	1,080.0				